

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Агуулга

1.Аудитын гэрчилгээ	3
2.Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.12. Шилэн дансны мэдээлэл	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3.Менежментийн захидал.....	12
4.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	15
а. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	15
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	16
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Г.БАЯСГАЛАН ТАНАА

2020.03.25 № 06/934
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

- Нэр бүхий 2 банкны төлбөр гүйцэтгэх чадвар буурснаас харилцах дансанд байрших 53,917.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгөд эрсдэл үүссэн;
- 2,546.6 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй зэрэг нь эрх ба үүрэг, оршин байх, батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудитын тайлан

2.1. Оршил

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Г.Баясгалан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн үндсэн хөрөнгийн хадгалалт хамгаалалтад анхаарах, биет бус хөрөнгийг зөв бүртгэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 3 дугаар сарын 15-наас 2020 оны 3 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Л.Мөнхцацрал хариуцаж хэрэгжүүлэв.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А-1/248 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол хүн бүрийг эрүүл мэндийн даатгалд хамруулж, даатгалын тогтвортой санг бүрдүүлэн, даатгуулагчийн хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг худалдан авдаг үйлчлүүлэгч төвтэй, нийгмийн хариуцлага бүхий менежментийг хэрэгжүүлэхэд оршино.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар үйл ажиллагааны чиглэл зорилтоо дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;
- Эрүүл мэндийн даатгалын сан бүрдүүлэх, орлого, зарлагын тэнцвэрийг ханган ажиллах, үйл ажиллагаагаа тайлагнах;
- Даатгуулагчийг төлөөлж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай тусламж, үйлчилгээний зардлын төлбөр тооцоо хийх гэрээ байгуулах, гэрээний биелэлтэд хяналт тавих, дүгнэх;
- Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа, тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагаас тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нь харгалзан сонгон шалгаруулах үйл ажиллагааг энэ хуулийн 14.9.11-д заасан журмын дагуу зохион байгуулах;
- Даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрт хяналт тавих, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад тусламж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх талаар зөвлөмж, заавар өгөх;
- Энэ хуулийн 14.9.1, 14.9.8-14.9.11-д заасан асуудлаар санал боловсруулж холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн Үндэсний зөвлөлөөр шийдвэрлүүлэх болон хуульд заасан бусад чиг үүрэг

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЭМДҮЗ-ийн 2019 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн 07 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтцийг шинэчлэн баталсан;
- Эрүүл мэндийн даатгалын сангийн салбарт мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулсан;
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”;
- Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалаар батлагдсан “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”;
- Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”;
- Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар батлагдсан “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ыг 1 дүгээр, “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлүүд”-ийг 2 дугаар, “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж, жишээ”-г 3 дугаар, “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын норм”-ыг 4 дүгээр, “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын норм”-ыг 5 дугаар хавсралтаар баталсан;
- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөн тогтоосон байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Эрүүл мэндийн даатгалын сангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн Acolous программ хангамж ашигладаг байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Эрүүл мэндийн даатгалын сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 10 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангаарх мөнгөн гүйлгээний тайлангийн нийт мөнгөн орлогыг сонгож, эрсдэлийн түвшнийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд орлогыг суурь үзүүлэлтээр сонгосон нь эх үүсвэрээс хамаарч, зардал хэрэгждэгтэй холбоотой бөгөөд 344,733.3 сая төгрөгөөс тооцон 3,447.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 4,696.2 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлтээс тооцсонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 144,939.9 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт орсон нь мөнгөн хөрөнгө, авлага, засгийн газрын хувь оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1

Мөнгөн хөрөнгө	574,335.0	557,520.3	(16,814.7)
Авлага	18,287.8	180,122.7	161,834.9
Урьдчилгаа	578.8	498.5	(80.3)
Бараа материал			
Үндсэн хөрөнгө			
Нийт хөрөнгө	593,201.5	738,141.5	144,939.9
Өр төлбөр	4,624.8	2,657.3	(1,967.5)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	588,576.8	735,484.2	146,907.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	593,201.5	738,141.5	144,939.9

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 16,814.7 сая төгрөгөөр буурсан нь Капитал банканд байршиж байсан мөнгөн хөрөнгийг авлагын дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

Авлагын данс үлдэгдлийн өөрчлөлт дараах хүчин зүйлсээс шалтгаалсан байна. Үүнд:

- Монгол банкны эрх хүлээн авагч татан буугдсан Капитал банканд байршиж байсан мөнгөн хөрөнгийн нэхэмжлэлийг 2019 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр 136,113.2 сая төгрөгөөр баталгаажуулж, Банкны тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.8 дахь хэсэгт заасан төлбөр барагдуулах дараалалд бүртгэснийг авлага дансанд бүртгэсэн;
- Хугацааны эцэст хүүг төлөх нөхцөлтэй хадгаламж байршуулснаас хүүгийн авлага 7,526.3 сая төгрөгөөр нэмэгдсэн;
- Төр төлбөрийг нь хариуцах иргэдийн даатгалын шимтгэлийн авлага 19,779.5 сая төгрөгөөр нэмэгдсэн;
- Нийгмийн даатгалын санд төвлөрч, оны эцэст шилжүүлж амжаагүй эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн авлага 3,721.9 сая төгрөгөөр буурсан зэрэг нөлөөлжээ.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 80.3 сая төгрөгөөр буурсан нь эрүүл мэндийн байгууллагуудад олгосон санхүүжилтийн зардлын гүйцэтгэлтэй холбоотой байна. Жилийн эцсийн байдлаар уг дансанд Эрүүл хүүхэд аяны хүрээнд урьдчилж олгосон 444.1 сая төгрөг, оны эцэст шилжүүлсэн тусламж үйлчилгээний урьдчилгаа 54.4 сая төгрөгийн төлбөр бүртгэлтэй байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 1,967.5 сая төгрөгөөр буурсан нь Элэг бүтэн Монгол хөтөлбөрийн хүрээнд бий болсон лабораториудад олгох өглөгийг барагдуулсантай холбоотой бөгөөд оны эцэст 7.9 сая төгрөгийн урьдчилж орсон орлого, 104.7 сая төгрөгийн татаас санхүүжилтийн өглөг, төрөөс шимтгэлийг нь хариуцах иргэдтэй холбоотой ХНХЯ-нд төлөх 2,651.3 сая төгрөгийн өглөг бүртгэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 738,141.5 сая төгрөг болж тайлант үеийн үр дүн 146,144.0 сая төгрөгөөр өссөн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, Засгийн газрын тусгай сангийн удирдлага нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг 402,244.8 сая төгрөгөөр төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 465,686.1 сая төгрөг буюу 115.8 хувиар биелэгдсэн нь Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 24 дүгээр “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолоор цалин нэмэгдсэн, Хөдөлмөр, нийгмийн гурван талт үндэсний хорооны 2018 оны 05 дугаар тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 320,000.00 төгрөг байхаар шинэчлэн тогтоосонтой холбоотой юм.

Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан 402,244.8 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 346,387.5 сая төгрөг буюу 86.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад даатгуулагчийн хурууны хээний бүртгэлийг нэвтрүүлж цахим системээр хянаж эхэлсэн, өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн эмнэлэгтэй хагас жилээс гэрээ байгуулсан, 15 лабораторийн даатгалын гэрээг түр зогсоосон зэргээс шалтгаалан төрийн өмчийн Эрүүл мэндийн байгууллагад олгох эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт 44,848.3 сая төгрөгөөр, хувийн хэвшлийн Эрүүл мэндийн байгууллагад олгох санхүүжилт 10,995.1 сая төгрөг, нийт сангийн зардал 55,875.3 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 10 эрсдэл тодорхойлж, горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 231,324.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 140,765.2 сая төгрөгийн алдааг залруулж, 16.4 сая төгрөгийн зөрчилд акт тогтоож, 53,917.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 36,625.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

1. Аудитын явцад дараах алдааг санхүүгийн тайланд залруулав. Үүнд:

- Татан буугдсан Капитал банктэй холбоотой 136,113.2 сая төгрөгийн авлагыг мөнгөн хөрөнгөд бүртгэсэн нь УСНББОУС-2 Санхүүгийн тайлангийн толилуулгын “Авлагад өнгөрсөн үйл ажиллагааны үр дүнд зээл болон тооцооны үндсэн дээр үүссэн, нэхэмжлэхийн үүрэг хангагдмагц мөнгө болж хувирах зүйлсийг хамааруулна” гэсэн заалттай нийцээгүй эрх үүрэг, бодитой оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэхдээ 3,931.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар баталсан Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах зааварт нийцээгүй, үнэн зөв, тодруулга ба толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 2018 оны хадгаламжийн 720.3 сая төгрөгийн хүүгийн орлого тайлант оны орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө” гэж заасантай нийцээгүй, тохиолдсон байх, иж бүрэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Нэр бүхий 2 банкны төлбөр гүйцэтгэх чадвар буурснаас оны сүүлд өгсөн 8,000.0 сая төгрөгийн төлбөрийн даалгавар биелэгдээгүй байна. Тайлант онд банкууд алдагдалтай ажиллаж, санхүүгийн байдлын тайланд тусгасан өөрийн хөрөнгийн хэмжээ сөрөг дүнтэй, эрсдэлийн сан нь үлдэгдэлгүй байгаа нь эдгээр банкны харилцах дансанд байршиж байгаа 53,917.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгөд эрсдэл үүссэнийг харуулж байна. Энэ нь Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Банк дараах шаардлагыг хангаж ажиллана: 16.1.1.заавал байлгах нөөц, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг Монголбанкнаас тогтоосон журмын дагуу зохих хэмжээ, хэлбэрээр хангахын зэрэгцээ хадгаламж эзэмшигч, харилцагчийн мөнгөн хөрөнгийг бүрэн байлгаж, тэдгээрийн анхны шаардлагаар гаргаж өгөх, шилжүүлэх”, 16.1.2-д “өөрийн хөрөнгийн хүрэлцээ, зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан, гадаад валютын болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Монголбанкнаас тогтоосон журмын дагуу биелүүлэх”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй

байхаар төлөвлөж, зарцуулах”, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн “Эрүүл мэндийн даатгалын байгууллагын чиг үүрэг”-ийн 16.1.2-т “эрүүл мэндийн даатгалын сан бүрдүүлэх, орлого, зарлагын тэнцвэрийг ханган ажиллах, үйл ажиллагаагаа тайлагнах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

2. Голомт банк нь ГБ2018/02112 дугаар гэрээ бүхий 25,000.0 сая төгрөгийн хадгаламжийн хүүгийн орлогыг 16.4 сая төгрөгөөр дутуу тооцож шилжүүлжээ. Хүүгийн орлогыг банкны тооцож, шилжүүлсэн дүнгээр тооцоо нийлж баталгаажуулан, данс бүртгэлд тусгасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл: 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.5.бүх орлого” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Аудитаар илэрсэн 36,625.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Элэг бүтэн монгол хөтөлбөрийн хүрээнд хамтарч ажилласан 28 лабораторид шалгалт хийн, зөрчил илэрсэн 15 лабораторийн гэрээг цуцалж, 3-н лабораторид 1,675.3 сая төгрөгийн акт тогтоожээ. Нэр бүхий 3 лаборатори актыг хүлээн зөвшөөрөөгүй, асуудлыг шийдвэрлүүлэхээр шүүхэд хандсан бөгөөд хэрхэн шийдвэрлэгдсэн нь анхаарал татахуйц байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Эрүүл мэндийн даатгалын сан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансанд байгууллагын санхүүгийн тайлан, орон тоо, төсвийн төсөл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээний мэдээлэл зэрэг нийт 16 төрлийн 8445 мэдээлэл оруулсны 99.0 хувийг хуулийн хугацаанд нь байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,194.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлагын биелэлт 75 хувь, 7,462.8 сая төгрөгийн 6 зөвлөмжийн хэрэгжилт 91.7 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Залруулагдаагүй 90,559.5 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 4,696.2 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул хязгаарлалттай дүгнэлт өгч байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд

үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Авлагын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Хөдөлмөр, нийгэм, хамгааллын яамнаас төр төлбөрийг нь хариуцах иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд 83,810.6 сая төгрөгийн /улсын төсөвт батлагдсан/ санхүүжилт олгосон байна. Эрүүл мэндийн даатгалын цахим системийн бүртгэлээр дээрх иргэдэд 103,595.9 сая төгрөгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн ба өссөн дүнгээр 26,501. 2 сая төгрөгийн авлага үүссэнийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 9.1.5-д “төр төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын байгууллагаар дамжуулан санхүүжүүлэхэд улсын төсвөөс олгох хөрөнгө”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүжилт хүрэлцэхгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтарч улсын төсөвт зардлын эх үүсвэрийг тусгуулах, авлагыг барагдуулах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

3.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Тусламж үйлчилгээний зардлыг цахим системээр хянаж баталгаажуулах, түүнийг баримтжуулах үйл явц нягтлан бодох бүртгэлийн циклд хэрэгждэг боловч энэ талаар бодлогын баримт бичигт тусгаагүй, анхан шатны маягтыг эрх бүхий удирдах байгууллагаар батлуулж ашиглаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”, 13 дугаар зүйлийн 13.3-т “Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 14.2-т зааснаас бусад өөрийн онцлогт тохирсон дотооддоо мөрдөх анхан шатны баримт, маягтыг дүрэмдээ заасан эрх бүхий удирдах байгууллагаар батлуулан мөрдөж болно” гэж заасантай нийцэхгүй байна.

3.2.2. Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн цикл алдагдах, хүчин төгөлдөр бус анхан шатны маягтаар гүйлгээ хийх

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Бодлогын баримт бичгийг салбарын онцлогт тохируулах, төлбөрийн хяналтын маягтыг батлуулах

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

3.3 Өглөгийн данстай холбоотой асуудал

3.3.1. Илрүүлэлт:

Урд онд үүссэн 2,546.6 сая төгрөгийн өглөгийг барагдуулах арга хэмжээ аваагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

3.3.2. Эрсдэл:

Он дамжсан өглөг үүсэх

3.3.3. Өгсөн зөвлөмж:

Өглөгийг тооцоо нийлж баталгаажуулан, барагдуулах арга хэмжээ авах

